

ANNEX 2 to the Minister of Culture, Sports and
Tourism A/41 Order of 08 Feb 2013

NATIONAL LIST OF INTANGIBLE CULTURAL HERITAGE IN
NEED OF URGENT SAFEGARDING

1. Mongol Tuuli: Mongolian Epic
2. Traditional Music of the Tsuur
3. Melodies for Coaxing Animals
4. Coaxing Ritual for Camel Calves
5. BiiBiiIlgée: Mongolian Traditional Folk Dance
6. Mongolian Traditional Practices of Worshipping Sacred Sites
7. The Art of Steel Carving
8. Traditional Art of Book-Making
9. Traditional Wedding Ceremonies of Different Mongolian Ethnic Groups
10. Traditional Performance Techniques of Folk Musical Instruments and Their Repertoire
11. Mongolian Traditional Tsam Dance
12. Mongolian Calligraphy
13. Traditional Forms of Puzzle Games
14. Circular Breathing Technique of the Limbe Performance
15. Performance of the Mongolian Jangar Epic
16. Mongolian Traditional Contortion

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын
2013 оны 02 сарын 08-ны өдрийн
9/41 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЯАРАЛТАЙ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ

1. Монгол тууль
2. Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг
3. Төл авахуулах ая дуудлага, зан үйл
4. Ингэнд ботго авахуулах зан үйл
5. Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг
6. Уул овоо тахих монгол зан үйл
7. Ган сийлбэрийн урлал
8. Ном бүтээх уламжлалт урлал
9. Монголын олон ястны хурим, найрын уламжлалт зан үйл (Боржигин найр, Баяд, Дөрвөд, Захчин, Казах, Урианхай, Буриад хурим)
10. Ардын хөгжмийн уламжлалт урын сан, хөгжимдөх арга барил (хуур, экилийн татлага, товшуурын аяз, домборын кюй)
11. Монгол цам
12. Монгол уран бичлэг
13. Онъсон тоглоомын уламжлалт төрлүүд
14. Лимбэ, бишгүүрийн битүү амьсгаа*
15. Монгол жангар
16. Монгол уран нугралт

**Амьсгалын эрхтний дотоод орчлоор тасралтгүй үлээж эгшиглүүлэх ховор хосгүй арга барил*



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 08 өдөр


Дугаар А/41

Улаанбаатар хот

Бүртгэл шинэчлэн батлах тухай

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-ын "Соёлын биет бус өвийг хамгаалах тухай" Конвенцийн 12.17 дугаар зүйл, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын "Биет бус соёлын өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-гийн конвенцийг хэрэгжүүлэх 2009 оны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын биет бус соёлын өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлийг нэгдүгээр, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Биет бус соёлын өвийн төрөл зүйлийн бүртгэлүүдийг ЮНЕСКО-д хүргүүлэх, хэвлүүлэн сурталчлах, шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэх арга хэмжээ авч ажиллахыг Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Оргил/, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс /Г.Жаргалсайхан/, Соёлын өвийн төв /Г.Энхбат/-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 84 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.



Ц.ОЮУНГЭРЭЛ

00000695